МОНГОЛД ӨВЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧАЛЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ ГАРГАХ

Б. Оюун-Эрдэнэ, Оксфорд Брукс Их Сургуульд, Tourism Management & International Relation, 2-р курсын оюутан.

Оршил

Аялал жуулчлал нь Монгол улсын эдийн засаг болон нийгэмд хөрөнгө оруулах нэгэн чухал үйлдвэрлэл болоод удаж байгаа билээ. Гэвч манай оронд өнөөгийн байдлаар энэхүү үйлчилгээний үйлдвэрлэл нь улирлын чанартай байгаа бөгөөд жуулчид хүлээн авч буй үндсэн хугацаа нь зун болон намар юм. Монголд зуны аялал жуулчлалыг идэвхитэй сурталчилснаар энэ улиралд ирэх жуулчдын тоо жил ирэх тутам өсөж байгаа билээ. Гэвч ирж буй нийт аялагчдын ердөө 20% нь буюу 80000 орчим нь өвлийн улиралд айлчилдаг гэсэн тооцоо байна. 11 сараас 2 сар нь өвлийн аялал жуулчлалын оргил үе бөгөөд зуны жуулчид хүлээн авах хугацаанаас 2 дахин богино байгаа юм. Үүнийг дагаад эдийн засаг болон нийгэмд олон асуудал гарч буйн заримаас дурьдвал, энэ салбарын ажиллах хүч нь мэргэжлийнхээ дагуу жилийн дөрвөн улиралд тогтвор суурьшилтай хөдөлмөрлөхөд бэрхшээлтэй байгаа бөгөөд жуулчид цөөн улирал нь тэднийг мэргэжлийн бус чиглэлээр ажиллах эсвэл ажилгүйчүүдийн эгнээнд нэгдэх гэсэн сонголтонд хүргэх хүчин зүйл болж байна. Мөн зочид буудал болон жуулчны баазууд гэсэн үйлчилгээний байгууллагууд нь өвлийн цагаар үндсэндээ зогсонги байдалд орж зуны улиралд ирж буй зочидоо байрлуулах боломжгүй болтолоо ачаалалтай болж зохицуулалт хийгдэх зайлшгүй хэрэгтэй байгааг харуулж байна. Өвлийн аялал жуулчлал нь энэ төрлийн аялал эрхлэгчдийн анхаарлыг татах болоод удаагүй боловч энэ улиралд манай оронд зохион байгуулж буй үйл ажиллагаанууд өргөжсөөр байгаа юм. Жишээлбэл Монгол түмний үндэсний баяр болох "Цагаан Сар" аас эхлэн "Хөвсгөл дэхь мөсний баяр, Бугын уралдаан, Тэмээний уралдаан, Өглөөний нар харах аялал, Чаргатай нохойн аялал болон Өвлийн наадам" гэх мэт олон аялал болон event-үүдийг Монгол дахь àÿëàëûí êîìïàíèуд жуулчдад өргөн барьж байгаа билээ. Түүнчлэн өвлийн улиралд манай оронд цас их хэмжээгээр унадаг нь өвлийн спорт хөгжүүлж болох таатай нөхцөл юм. Ардын уламжлалт баяр болох Цагаан сар нь энэ улиралд

зохиогддог, өвөрмөц өөрийн гэсэн хэв шинжийг хадгалж чадсан ёс заншил билээ. Хэдийгээр Хятадын шинэ жилтэй бараг ойролцоо хугацаанд болдогч зан үйлийн хувьд хоорондоо ялгаатай гэдгийг гадныханд таниулж сурталчлах нь чухал юм. Мөн манай оронтой цаг агаар байгалийн тогтоц зан заншилаараа адил Өвөр Монголын Өөртөө Засах Орон нь өвлийн аялал жуулчлалаа хөгжүүлэх тал дээр онцгой анхаарал тавин гадаад дотоодод хүчтэй сурталчилгаа явуулж байгаа нь биднийг хоцорч болохгүйг сануулж байна. Хэдий өвлийн аялал жуулчлалыг Монголд хөгжүүлэх боломж өргөн байгаа мэт харагдаж байгаа ч одоо байгаа болон тохойлдож болох саад бэрхшээлүүдийг тооцоолон үзэх нь чухал билээ. Иймд өвлийн аялал жуулчлалыг дэлгэрүүлэх ба нийт аялал жуулчлалаас олох ашгыг тогтворжуулан цаашид хурдацтайгаар нэмэгдүүлэхийн тулд хөгжлийн төлөвлөгөөг засгийн газар, хувийн ба төрийн бус байгууллагууд хамтран гаргах нь нэн тэргүүний асуудал юм. Энэ илтгэлд Монголын өвлийн аялал жуулчлалын нөхцөл байдал дээр тулгуурлан хөгжлийн төлөвлөгөөний бүтэц болох тодорхой зорилго тавих, төслийн багийг бүрдүүлэх, одоогийн нөхцөл байдалыг тодорхойлох, ирээдүйн чиг хандлагыг таамаглах, тусгай хөтөлбөр бэлдэх, үүнийгээ амьдралд хэрэгжүүлэх болон хянах зэргийг задлан тайлбарласан болно. Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх төлөвлөгөө нь өргөн хүрээтэй асуудал болохоор илтгэлд зөвхөн ерөнхий төлөвлөгөө гаргах бүтэц дээр тулгуурлан цөөхөн жишээ оруулав.

1. Зорилт

Хөгжлийн төлөвлөгөөний зорилго нь Монголд аялал жуулчлалын улиралыг уртасган үр өгөөжийг нэмэгдүүлэх болон Монголыг өвлийн аялал жуулчлалын бүс гэсэн утгаар дэлхийд таниулàхад чиглэсэн болно.

2. Төслийн багийг бүрдүүлэх

Аялал жуулчлал нь өөрөө шууд ба шууд бус утгаар сайн ба муу олон үр дагаврыг байгаль орчин, эдийн засаг, нийгэмд үзүүлж байдаг учир Монголд өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх төлөвлөгөөг зөвхөн энэ салбарын мэргэжилтэнүүд гаргах нь тохиромжгүй бөгөөд өрөөсгөл юм. Иймд аялал жуулчлалын мэргэжилтэнүүдээс гадна техникийн инженерүүд маркетингийн мэргэжилтнүүд, төлөвлөгөө гаргагчид

ба эдийн засагчид гэсэн 4 үндсэн салбарын мэргэжилтэнүүдээс энэ төслийн багийг бүрдүүлж болох юм. Үүнийг илүү дэлгэрэнгүй болгон задалвал:

- Маркетингийн аналистууд
- Эдийн засагчид
- Байгаль орчины судлаачид
- Дэд бүтцийн инженерүүд
- Зам тээврийн инженерүүд
- Нийгэм судлаачид
- Зохион бүтээгчид
- Хуулийн мэргэжилтэнүүд нь энэ төслийг бэлдэх болон амилуулахад шаардлагатай боловсон хүчинүүд юм.

3. Одоогийн байгаа нөхцлийг тодорхойлох

а. Монголыг зорин ирж буй жуулчдын зан чанар болон нийгмийн бүтэцийг судлах

Судалгаанаас харахад Монголд ирж буй жуулчид нь ихэвчлэн Орос, Хятад, Япон, Хойд Америк болон Баруун Европын иргэд байгаа бөгөөд насны хувьд талаас дээш хувь нь 45 ба түүнээс дээш насныхан, дийлэнх аялагчид нь дээд боловсролтой байна. Тэдний нийтлэг зан чанар нь 'өөртөө итгэлтэй, сониуч, адал явдалд дуртай, шинийг санаачлах дуртай' гэсэн байна.

б. Хэрэглэгчдийн хийж байгаа сонголтыг судлах

Жишээлбэл: Жуулчдын Монголыг сонгон аялахад хүргэсэн хүчин зүйлсэд нүүдэлчин ахуй, уламжлалт амьдарлын хэв маяг, ёс заншлаас гадна хүний гараар бүтсэн болон байгалын үзмэрүүд ордог байна.

в. Газар ашигласан байдал, газар эзэмшилт ба түүнд тавьж буй хяналтыг судлах.

Жишээлбэл: Үүнд Монголд буй дотоодын болон гадаадын байгууллагууд газрыг хэрхэн зөв зохистой ашиглаж байгааг тогтоох бас улсаас энэ асуудалд хяналт тавиж чадаж байгаа эсэхийг тодруулна.

г. Монголд байгаа хүний гараар бүтсэн болон байгалын үзвэрүүдийг судлах.

Жишээлбэл: Энд олон зүйлсийг дурдаж болох бөгөөд, байгалын үзэмжит тогтоц; өвлийн улиралд нүд гялбам цасаар хучигдсан тал, цэвэр агаар, ховор ан амьтан болон хуучны сүм хийдүүд гэх мэт нь гадны жуулчдыг Монголруу татах хүчин зүйлсүүд бөгөөд цаашдаа энэ чигээрээ хамгаалагдан хадгалагдаж үлдэх нь чухал юм. Судалгаанаас харахад манай оронд ирж буй нийт жуулчдын хамгийн их хувь нь буюу 40% нь Говьд айлчилдаг, үүнд Баянзагын эртний үлэг гүрвэлийн өндөг болон ясыг олсон газрууд, Хонгорын Элс, Ёлын Ам гэх мэт байгалийн тогтоцууд орно. Түүнчлэн Өвөрхангай аймаг нь 2 дахь хамгийн их жуулчид очдог газар бөгөөд эртний нийслэл Хар Хорин, Улаан Цутгалан, Хөгнө Хан Уул нь энэ бүсээс онцолж болох олон үзмэрүүдийн цөөн хэд нь юм. Харин Тэрэлж ба Хөвсгөл Нуур нь 3 дахь жуулчдын очихыг хүсдэг газар гэж нэрлэгдсэн байна.

д. Ýêîñèñòåì-ийн хүчин зүйлсүүдийг судлах, ялангуяа хүчин мөхөсдөж байгаа хэсгийг.

Жишээлбэл: Агаарын болон хөрсний бохирдол, шинээр барилга байшин барьж байгаатай холбоотой гарч буй хөрсний элэгдэл болон цэвэр усны хомсдол, мөн тухайн орчинд оршин байсан ан амьтан болон ургамалыг сүйтгэн үгүй хийх; үүнд хулгайн ан, модыг хайр найргүй тайрч түлшинд эсвэл барилга барихад хэрэглэснээс үүдэн цөлжилт явагдах гэх мэт аялал жуулчлалтай холбоотой байгаль орчинд учирч буй олон сөрөг үр дагаварыг нэрлэж болно.

е. Монголын эдийн засгын бүтэц ба аялал жуулчилалын боломжыг судлах.

Жишээлбэл: Манай орны хувьд өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэхэд зориулан шинээр цанын бааз гэх мэт өндөр чанартай үйлчилгээний төвүүд барих, зам тээврийг сайжруулан засахад улсаас гаргаж чадах төсөв бага, хувийн байгууллагуудын эдийн засгийн ÷àâàð хүрэхгүй çýðãýýñ ¿¿äýí гаднаас хөрөнгө оруулалт зээл тусламж авах болон гадны байгууллагуудтай хамтран ажиллах шаардлагатай болно.

ё. Ажиллах хүчний чадвар, суурь боловсрол, нөөц бололцоог судлах.

Жишээлбэл: Монголд ерөнхий ажиллах хүчний нөөц бололцоо багатай боловч аялал жуулчлалын чиглэлээр суралцаж байгаа болон энэ чиглэлээр ажиллах сонирхолтой хүмүүсийн тоо нэмэгдэж байгаа. Гэвч зуны цагт дадлагын оюутнууд

ажиллуулж байсан жуулчны бааз болон хөдөө дахь үйлчилгээний газарууд өвлийн цагаар хүн хүчний дутагдалд ордог байна.

ж. Байрны боломж (зочид буудал, баазууд гэх мэт) -ыг судлах.

Жишээлбэл: Одоогийн байгаа зочид буудал, guest house-ууд, гэр баазуудын үйлчилгээний чанар стандартыг шалган тогтоох àòòåñòà÷èëëàõ нь чухал юм. Мөн өвлийн улиралд хөдөө орон нутагт ажилладаг үйлчилгээний байгууллагууд цөөн байдгыг анхаарах хэрэгтэй юм.

з. Жуулчдад зориулсан үйлчилгээнүүдийг судлах.

Улаанбаатар болон хөдөө орон нутагт өвлийн цагаар ажилладаг ресторан, үзвэр, тоглолт, үзүүлэн, мүзей болон тэдний үйл ажиллагаа, үйлчилгээний цар хүрээ, байршил, цагийн хуваарийг тодруулан бүртгэх болно.

к. Дэд бүтцийг судлах

Манай орны дэд бүтэц сүүлийн жилүүдэд ахицтайгаар хөгжиж байгаа боловч орон нутагт энэ тал дээр хангалтгүй үзүүлэлттэй байгааг анхаарч үзүүштэй юм. Үүнд утсан харилцаа, цахилгаан, цэвэр усны сүлжээ гэх мэт орно.

л. Зам тээврийн хөгжлийг тодорхойлох.

Өнөөгийн нөхцөлд Монголын зам тээврийн хөгжил нэлээд хоцрогдож байгаа нь үнэн бөгөөд гаднаас ирж буй болон гарч буй нислэгийн тоо цөөн, өндөр үнэтэй байгаа. Үүнээс гадна хотоос гадагш засмал зам олон биш, системтэй бүртгэгдээгүй, тэмдэг тэмдэглэлгээгүй гэсэн дутагдлууд байсаар байгаа юм. Мөн орон нутгийн онгоцууд, жуулчны автобусууд аюулгүй найдвартай үйлчилж байгаа эсэхийг судлах хэрэгтэй билээ.

4. Ирээдүйн чиг хандлага

Жуулчдын цаашдын хэрэгцээ сонирхлын өөрчлөлт болон эрэлтийг судална. Ингэхдээ бүтцийн шаардлага болон ирээдүйн бүтээгдэхүүний шат бүрийн үйлчилгээ биет материалыг оролцуулан судалснаар хэрэгжүүлэх боломжтой болно. Жишээлбэл: Монголыг сонирхох жуулчдын тоо цаашид ч өсөх хандлагтай байгаа бөгөөд, дэлхий нийтийн хандлага тогтвортой аялал жуулчлал ба ýêîòóðèçìûг дэмжихэд чигэлж байгаа өнөөгийн нөхцөлд манай орон ч мөн байгаль орчноо хамгаалсан, нийгэмд болон эдийн засагт үзүүлж буй нөлөө нь сөрөг бус эерэг байх

гэсэн бодлогыг баримтлан энэ үйлдвэрлэлийг сурталчлах нь үр өгөөжтэй байх болов уу. Үүнээс гадна урьдчилан таамагласан үйлчилгээний стандарт нь шалгагдах хэрэгтэй бөгөөд орон нутгийн эдийн засагт учирч болох хохирол нь тогтоогдох болно.

5. Тодорхой төслийн загварыг бий болгох

Төлөвлөгөөний энэ шатанд хэрхэн Монгол дах ь өвлийн аялал жуулчлалыг дэлхийд сурталчлах маркетингийн болон менежментийн бодлогын дүгнэлтүүд багтана. Жишээлбэл: ITB, WTC гэсэн олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцож буй төрийн болон хувийн байгууллагууд нь тарааж буй сурталчилгааны материалуудаа өвлийн аялал жуулчлалтай холбоотой мэдээллүүдийг илүү түлхүү оруулж өгж болно. Мөн техникийн хөгжлийг орхигдуулж болохгүй бөгөөд Монголыг болон өвлийн аялал жуулчлалыг цахим ертөнцөд сурталчилах нь өнөөгийн глобалчлагдаж байгаа нийгэмд мэдээлэлийг түгээх хамгийн үр ашигтай зардал багатай арга байж болох юм. Түүнчлэн энэ төлөвлөгөөний загварыг гаргахад зохион бүтээгчид болон физикийн төлөвлөгөө гаргагчид нь Монголын ахуй зан заншилтай уялдсан зөвхөн манай орны гэсэн брэнд болж чадах онцгой өвөрмөц шийдэл бүхий зохиомжуудыг гарган үүндээ дэд бүтэцийн болон хөгжлийн асуудлыг хэрхэн шийдвэрлэхийг тусгаж болно. Жишээлбэл үүнд орчин цагын жуулчдын шаардлагыг хангасан, сонирхолыг нь татахуйц засалтай өвлийн цанын баазуудыг бүтээн босгож болох юм. Эдгээр барилга байгууламжын загварыг хөгжүүлэхэд шаардлагатай зардалуудыг болон нийт төлөвлөгөөнд зориулан гаргах хөрөнгийг эдийн засагчид дүгнэх бөгөөд үүнтэй холбоотой дэд бүтцийг хөгжүүлэх эдийн засагийн хөрөнгө оруулалтыг хаанаас хэрхэн бий болгох гэсэн асуудал нь хамгийн чухал шийдлүүдийн нэг болно. Түүнчлэн байгаль орчны мэргэжилтэнүүд нь тухайн орчны ýêîñèñòåìä тулгамдсан асуудлуудыг тодорхойлж учирч болох хор хохирлыг багасгах аргыг олно. Байгаль орчны зохицуулалттай холбоотой авч болох арга хэмжээнүүд нь өргөн хүрээг хамрах бололцоотой юм. Жишээлбэл: цэвэр усны нөөцийг хадгалах, хамгаалах, тохижилт явагдах хэсгийн ан амьтан, хөрсийг бага гэмтээх, хохироох аргыг олох гэх мэт. Мөн ирээдүйд учирч болох байгаль орчны өөрчлөлтүүдийг урьдчилан таамаглаж төлөвлөгөөнд тусгах хэрэгтэй бөгөөд

жишээлбэл дэлхийн дулаарлаас үүдэн ирээдүйд Монголд орох цасны хэмжээ багасна гэснийг энэ төсөлд бодолцож үзэх нь чухал юм. Учир нь ийм нөхцөлд хүрвэл хөрөнгө ихээр зарж хийсэн өвлийн спорттой холбоотой барилга төхөөрөмжүүд нь ашиглагдахгүй, үргүй зардал болон хувирах аюултай.

6. Биелэлт болон түүнийг хянах

Барилга байгууламжын бүтэц ба зааварчилгаа, техникийн ба зохион байгуулалтын тусламж, хөрөнгийн анализ, задлан шинжилгээтэйгээр энэ хөгжлийн хөтөлбөр нь хэрэгжиж эхэлнэ. Мөн санал болгогдсон дэд бүтэцийн хөрөнгө оруулалтын төслийг эхлүүлж цаашдын хэрэгжилтэнд хяналт тавих ба хэрэгжиж буй үйл ажиллагааг зорисон зорилгодоо хүрэхийн тулд боломжоо äýýä çýðãýýð aøèãëaæ байгаа эсхийг дахин нягтлах нь биелэлтийн үед хийгдэх болно.

7. Төгсгөл

Эцэст нь Монголд өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх боломж байгаа бөгөөд цаашид үүнийг ул сууритай судлан хэрэгжүүлэхийг санал болгож байна.